



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 4/40

Чойр

Албан тушаалын тодорхойлолтыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны “Зөвшөөрөл олгох тухай” 340 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зөвлөлөөс батлахыг зөвшөөрсний дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн (Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийг хариуцах)-ий албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Дотоод ажил, өргөдөл, гомдол, санал, хүсэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Гадаад харилцаа, нутгийн захиргааны бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Эрх зүйн сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, авлигын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Хууль, тогтоомжийн мэдээлэл системчлэл, захиргааны хэм хэмжээний акт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Гэрээний хяналт, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ерөнхий санхүүчийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Бүртгэл, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн (Нягтлан бодох бүртгэлийн Улсын байцаагч)-ийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Төрийн сангийн тооцооны мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ, үйлдвэржилтийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 12 дугаар, Байгаль орчин, аялал жуулчлал, ус, цаг уур, орчны шинжилгээ, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Газрын харилцаа, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Барилга, хот байгуулалт, тохижилтын бодлого

хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа, концессийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, жендэрийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18, Гэр бүл, хүүхэд, залуучууд, боловсрол, шинжлэх ухааны бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Соёл урлаг, биеийн тамир, спортын бодлого төрийн бус байгууллага хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргүүдийг хэрэгжүүлж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай

3. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/62 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.СОДНОМ